



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 3 дугаар
сарын 1-ний өдөр


Дугаар 30

Улаанбаатар
хот

Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай


1. Агаарын тухай хуулийн 6.1.1¹, 6.2-т заасныг тус тус үндэслэн агаар, орчны бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Үндэсний хороог шинэчлэн байгуулах тухай” Ерөнхий сайдын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Ерөнхий сайдын 2022 оны 30 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- Гишүүд:
- Батлан хамгаалахын дэд сайд;
 - Гадаад харилцааны дэд сайд;
 - Сангийн дэд сайд;
 - Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
 - Эдийн засаг, хөгжлийн дэд сайд;
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;
 - Барилга, хот байгуулалтын дэд сайд;
 - Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд;
 - Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;
 - Соёлын дэд сайд;
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
 - Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд;
 - Эрчим хүчний дэд сайд;
 - Эрүүл мэндийн дэд сайд;
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
 - Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
 - Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга;

-Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч;

-Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх;

-Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх;

-Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга;


-Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал;

-“Монголын байгаль орчны иргэний зөвлөл” Төрийн бус байгууллагын тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Үндэсний хорооны Ажлын албаны дарга.

---o0o---



Ерөнхий сайдын 2022 оны 30 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр, бусад хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрт заасан агаар, орчны бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулах, төрийн байгууллагуудын харилцан уялдааг хангуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хорооны үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа агаар, орчны бохирдлыг бууруулахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, холбогдох бусад стандарт, дүрэм, энэ журмыг баримталж, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана.

Хоёр.Үндэсний хорооны чиг үүрэг, эрх

2.1.Үндэсний хорооны гишүүд батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилт, үйл ажиллагаа тасалдахгүй байхад анхаарч ажиллана.

2.2.Үндэсний хороо нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1.агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагуудад үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

2.2.2.агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын салбар дундын үйл ажиллагааг зохицуулах;

2.2.3.агаар, орчны бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих, урамшуулах;

2.2.4.төрийн болон төрийн бус байгууллагуудаас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, мэдээ тайланг гаргуулж авах, холбогдох албан тушаалтны сонсгол, тайланг хэлэлцэх, шаардлагатай арга хэмжээний талаар шийдвэр гаргах;

2.2.5.Үндэсний хорооны стратеги төлөвлөгөө болон тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

2.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

2.3.Үндэсний хороо нь дараахь эрхийг хэрэгжүүлнэ:

2.3.1.агаар, орчны бохирдлыг бууруулах талаарх судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллага болон гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, дүгнэлт гаргуулах;

2.3.2.Үндэсний хорооны гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг шаардах, зарчмын зөрүүтэй саналаа хуралдааны тэмдэглэлд тусгуулах;

2.3.3.агаар, орчны бохирдлыг бууруулах асуудлаар Засгийн газрын шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.3.4.агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний давхардал хийдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөмж гаргаж хэрэгжилтийг хангуулах;

2.3.5.Үндэсний хорооны хуралдааны дэгийг хэлэлцэн батлах;

2.3.6.гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэдний сайн туршлагыг нэвтрүүлэх, үр дүнг тооцох;

2.3.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

2.4.Үндэсний хороо, Ажлын алба нь үйл ажиллагаандаа зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав.Үндэсний хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1.Үндэсний хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2.Үндэсний хорооны ээлжит хуралдааныг улирал тутам зохион байгуулна. Ээлжит хуралдааны товыг жилээр төлөвлөж, Үндэсний хорооны дарга батална. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хорооны даргын санаачилгаар болон гишүүдийн 50-аас дээш хувийн саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

3.3.Хуралдааныг танхимаар болон цахимаар зохион байгуулж болно. Үндэсний хорооны дарга хуралдааныг даргалах бөгөөд гишүүдийн олонх нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.4.Үндэсний хорооны гишүүн ээлжит хуралдаанаас 14 хоногийн өмнө холбогдох ажлын тайлан, мэдээг ирүүлнэ. Ажлын алба хуралдаанаар хэлэлцэх асуудлын холбогдох материалыг хуралдаан товлогдсон өдрөөс 3 хоногийн өмнө Үндэсний хорооны гишүүдэд хүргүүлсэн байна.

3.5. Үндэсний хорооны ээлжит хуралдаанд дарга, гишүүд заавал биеэр оролцоно. Ээлжит бус хуралдаанд гишүүд биечлэн болон цахимаар оролцох боломжтой бөгөөд хүндэтгэх шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа албан бичгээр ирүүлсэн байна.

3.6. Үндэсний хорооны гишүүн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбогдуулан саналаа албан бичгээр ирүүлж болно. Энэ тохиолдолд гишүүнийг хуралдаанд оролцсоноор тооцно.

3.7. Үндэсний хороо нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж, гүйцэтгэлийн тайланг хагас жил, бүтэн жилээр гаргаж, хэлэлцэж дүгнэнэ.

Дөрөв. Үндэсний хорооны хуралдааны шийдвэр

4.1. Үндэсний хороо нь хууль тогтоомж болон энэ журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй, холбогдох хуульд тогтоомжид нийцсэн байна.

4.2. Хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй асуудалд урьдчилан тайлбарыг бичгээр гаргах бөгөөд санал өгөхгүй байна.

4.3. Үндэсний хорооны хуралдааны тэмдэглэлийг хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Хэрэв дарга өөр саналтай бол гишүүдийн олонхоороо шийдвэрлэсэн асуудлаар гарсан шийдвэрт гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

4.4. Үндэсний хорооны гишүүд нь хуралдаанаас гарсан шийдвэрт хамтын хариуцлага хүлээнэ.

4.5. Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох байгууллага, хариуцсан албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй бөгөөд явц, үр дүнг тогтоосон хугацаанд тогтмол тайлагнана.

4.6. Үндэсний хорооны хуралдааны тогтоол, шийдвэрийн төсөл, Хорооны даргын тушаалын төслийг ажлын албаны мэргэжилтэн архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулж, хянаж, албажуулах ажлыг гүйцэтгэнэ.

Тав. Ажлын алба

5.1. Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг “Ажлын албаны дотоод журам”-аар зохицуулна. Ажлын албаны дотоод журмыг Үндэсний хороо батална.

5.2. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргыг Үндэсний хорооны даргын санал болгосноор Үндэсний хороо хуралдаанаараа хэлэлцэн тогтоол гаргаж томилж, чөлөөлнө.

5.3. Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн Ажлын албаны ажилтнуудыг Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд

Ажлын албаны дарга томилж, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах, урамшуулах шийдвэр гаргана.

5.4. Ажлын албаны орон тооны хязгаар 8 хүртэл байх бөгөөд ажлын албаны үйл ажиллагааны санхүүжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлаас олгоно.

5.5. Ажлын алба нь дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гарсан Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.5.2. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагуудад үүрэг даалгавар өгөх, холбогдох ажлын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

5.5.3. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах, санал өгөх, ажлын хэсэгт орж ажиллах, комисс байгуулан ажиллах, шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангах;

5.5.4. Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд холбогдох яам, газар, албан тушаалтнаас мэдээ мэдээлэл, тайлан авах, нэгтгэх, салбар хоорондын уялдааг сайжруулах, дэд ажлын хэсгүүдэд чиглэл өгөх, Үндэсний хорооны гишүүдийг мэдээллээр хангах;

5.5.5. Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зөвлөлдөх үүрэг бүхий салбарын эрдэмтэн мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон орон тооны бус эрдэмтдийн зөвлөл ажиллуулах;

5.5.6. Ажлын алба нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зохих журам, маягт (загвар)-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.5.7. Хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлд заасан үүрэг, даалгаврыг төрийн захиргааны байгууллага болон нийслэл, аймаг орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгөх, хяналт тавих, хэрэгжилтийг хангах;

5.5.8. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангах, бүх нийтийн оролцоог хангасан ажлыг зохион байгуулах;

5.5.9. Агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан нийслэл, орон нутгийн холбогдох албан тушаалтанг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах, мэдээ, тайлан гаргуулах;

5.5.10.Орчны төлөв байдлын болон агаар, хөрс, ус бохирдуулагч эх үүсвэрийг тогтоох, бохирдлыг бууруулах, зогсоох чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт, шалгалт хийх, дүнг хорооны хуралд танилцуулах, авах арга хэмжээний шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.5.11.Үндэсний хорооны ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны улирал, хагас жил, жилийн тайланг боловсруулж танилцуулах, Засгийн газар бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулах;

5.5.12.Олон улсын байгууллага болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагатай агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах;

5.5.13.Үндэсний хорооны хуралдааны үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг хангах;

5.5.14.холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

---oOo---